

Сангийн сайдын 20.. оны ... сарын ...-ны  
өдрийн ... дүгээр тушаалын .. дугаар  
хавсралт

## **МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

**ТЕНДЕР ҮНЭЛЭХ, ТЕНДЕРТ  
ОРОЛЦОГЧДОД ДАВУУ ЭРХ ОЛГОХ  
АРГАЧЛАЛ, ЗААВАР**

## ӨМНӨХ ҮГ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагч нь тендерийг тендерийн баримт бичиг, хууль тогтоомжид нийцүүлэн хурдан шуурхай хянан үзэх, үнэлэхэд алдаа дутагдал гарахаас сэргийлэх зорилгоор энэхүү аргачлал, зааврыг боловсрууллаа. Захиалагч, үнэлгээний хороо энэ аргачлал, зааврыг баримтлан тендерийн үнэлгээ хийнэ.

Тендер хянан үзэх, үнэлэх явцад гарсан алдаа дутагдал нь захиалагч үнэлгээний дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх, улмаар оролцогчдын зүгээс худалдан авах ажиллагаатай холбоотой гаргах гомдол, маргааныг нэмэгдүүлж, худалдан авах ажиллагаа цаг хугацаандаа үр ашигтай хэрэгжихгүй байх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Энэхүү аргачлал, заавартай холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу.

Сангийн яамны Хууль эрх зүйн газрын  
Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс  
Утас: 260206, 267416, 267648

Худалдан авах ажиллагааны цахим систем: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

# Агуулга

<b>БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b> .....	1
1. Зорилго .....	1
<b>БҮЛЭГ II. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ</b> .....	1
2. Тендерийг хянан үзэх.....	1
<b>БҮЛЭГ II. БАРАА, АЖИЛ, ЗӨВЛӨХӨӨС БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕНДЕРИЙГ ҮНЭЛЭХ</b> .....	4
3. Тендерийн үнийг тодорхойлох.....	4
4. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох, тендерт оролцогчид олгох давуу эрхийг тооцоолох.....	4
5. Бараа нийлүүлэх тендер ирүүлсэн оролцогчид давуу эрх олгох.....	5
6. Ажил гүйцэтгэх тендер ирүүлсэн оролцогчид давуу эрх олгох.....	6
7. Тендерийг харьцуулах.....	7
<b>БҮЛЭГ III. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНАЛ ҮНЭЛЭХ</b> .....	8
8. Зөвлөх үйлчилгээний хураангуй жагсаалтад орох саналыг хянах.....	8
9. Зөвлөх үйлчилгээний техникийн санал үнэлэх.....	8
10. Зөвлөх үйлчилгээний санхүүгийн санал үнэлэх.....	9
<b>Маягт 1</b> Тендер шалгаруулалтын товч мэдээлэл.....	1
<b>Маягт 2</b> Тендерийн нээлтийн тэмдэглэлийн загвар.....	2
<b>Маягт 3</b> Тендерт оролцогчийн тендерийг хянан үзэх тэмдэглэлийн маягт.....	3
<b>Маягт 4</b> Санал болгосон бараа, ажил, үйлчилгээ шаардлага хангах эсэхийг хянан үзсэн тэмдэглэл 5	
<b>Маягт 5</b> Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх голлох нөхцөл нь шаардлага хангах эсэхийг хянан үзсэн тэмдэглэл.....	6
<b>Маягт 6</b> Тендерийн үнэ тодорхойлох хүснэгт.....	7
<b>Маягт 7</b> Нэмэлт тохируулга хийх хүснэгт.....	8
<b>Маягт 8</b> Тендерт оролцогчид олгох давуу эрх тооцоолох маягт.....	9
<b>Маягт 9</b> Тендер шалгараагүй тухай мэдэгдлийн загвар.....	11
<b>Маягт 10</b> Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн загвар.....	13
<b>Маягт 11</b> Зөвлөх үйлчилгээний санал ирүүлэх урилгын загвар.....	14
<b>Маягт 12</b> Зөвлөх үйлчилгээний хураангуй жагсаалтад ороогүй тухай мэдэгдлийн загвар ..	15
<b>Маягт 13</b> Зөвлөх үйлчилгээний техникийн санал үнэлэх шалгуур үзүүлэлтийн загвар.....	16
<b>Маягт 14</b> Зөвлөх үйлчилгээний техникийн оноо үнэлэх хүснэгт.....	17
<b>Маягт 15</b> Зөвлөх үйлчилгээний тендерт оноо өгөх хүснэгтийн загвар.....	18
<b>Маягт 16</b> Зөвлөх үйлчилгээний техникийн саналын оноо өгсөн тухай мэдэгдлийн төсөл ..	20
<b>Маягт 17</b> Зөвлөх үйлчилгээний санхүүгийн саналын нээлтийн тэмдэглэл.....	21
<b>Маягт 18</b> Хосолмол үнэлгээний аргаар гэрээ байгуулах эрх олгох хүснэгт.....	22

# ТЕНДЕР ҮНЭЛЭХ, ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ДАВУУ ЭРХ ОЛГОХ АРГАЧЛАЛ, ЗААВАР

## БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 1. Зорилго

1.1. Энэхүү Тендер үнэлэх, тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал, заавар (цаашид “**заавар**” гэх)-ыг захиалагч болон үнэлгээний хорооны зөвлөхөөс бусад үйлчилгээ, бараа, ажлын тендерийг Тендерийн баримт бичигт заасны дагуу хянан үзэх, үнэлэх, бараа, ажлын тендер ирүүлсэн этгээдэд давуу эрх олгох, тендерээс татгалзах, гэрээ байгуулах эрх олгоход баримтална.

1.2. Тендер хянан үзэх, үнэлэх зорилго нь тендерийн баримт бичигт заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө холбогдох журмыг баримтлан ирүүлсэн тендерээс шаардлага хангасан, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тодорхойлоход оршино.

1.3. Захиалагч нь тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд багтаан хурдан шуурхай зохион байгуулахын тулд тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг тендер нээсэн өдөрт нь багтаан эхлүүлж, ажлын 3 хоногийн дотор дуусгавар болгоно.

1.4. Тендерийг хянан үзэх, үнэлэхээс өмнө захиалагч тендер шалгаруулалтын “Ерөнхий мэдээлэл”-ийг Маягт 1-ийн дагуу бэлтгэнэ.

## БҮЛЭГ II. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ

### 2. Тендерийг хянан үзэх

2.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө хүлээн авсан тендерийг тендерийн баримт бичигт заасны дагуу нээж, нээлтийн тэмдэглэлийг Маягт 2-ын дагуу үйлдэнэ.

2.2. Тендерийн нээлтийн тэмдэглэлийг тендерт оролцогч, түүний төлөөлөгч болон бусад сонирхогч этгээдэд танилцуулж, гарын үсэг зуруулна.

2.3. Захиалагч тендерийг хянан үзэх зорилго нь хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан эсэхийг тогтоох явдал бөгөөд ийнхүү хянан үзэхдээ тус зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийг удирдлага болгоно.

2.4. Захиалагч тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэхдээ тендерт оролцогч болон тендер тус бүр нь шаардлага нийцэж буй эсэхийг хянан үзэж, Маягт 3-ыг бөглөнө.

2.5. Тендертэй холбоотой тайлбар, тодруулга авах шаардлагатай гэж үзвэл захиалагч энэ талаар тендерийн баримт бичигт заасан ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулна.

2.6. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон мэдээллийн баазаас тендерт оролцогчдын талаарх мэдээллийг татаж авахдаа бүх тендерт оролцогчдын хувьд нэг ижил өдөр, цагт татан авч хянан үзэх зарчмыг баримтлах нь зүйтэй. Хэрэв цахим систем болон бусад мэдээллийн баазын ажиллагаанаас шалтгаантай биш бол энэ өдөр нь тендер хүлээн авах эцсийн өдөр байвал зохино.

#### Тендерийн баталгаажуулалтыг хянан үзэхэд анхаарах зарим асуудал

2.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Тоон гарын үсгийн гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцно” гэж, 6.2 дахь хэсэгт “Тоон гарын үсгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ бүхий иргэн, хуулийн этгээд хэрэглэж болно” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тооны гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ” гэж тус тус заасан тул эрх бүхий этгээдийн тоон гарын үсгээр баталгаажсан тендерийн маягтуудыг тендерт оролцогчийн эрх бүхий этгээд гарын үсэг зураагүй, эсхүл хуулийн этгээдийн тамга, тэмдэг дараагүй гэх үндэслэлээр татгалзахгүй.

2.8. Тендерийг хянан үзэхдээ тухайн тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд нь хэн болох, тухайн төлөөлөх эрх бүхий этгээд эсхүл түүнээс эрх олгогдсон этгээд -нь тендерийн маягтуудад гарын үсэг зурсан, тоон гарын үсэг зурсан эсэхийг шалган тогтоох нь зүйтэй юм.

2.9. Тендерийг илгээх, баталгаажуулахад гаргасан алдаа, зөрчил нь тендерийн хүчинтэй байдал, түүнд агуулагдсан баримт бичгийн хүчин төгөлдөр байдал, тухайн тендерийн дагуу шалгарсан тохиолдолд хүлээх үүргийн талаар үндэслэл бүхий эргэлзээ үүсгэх тохиолдолд тендер шаардлага хангахгүй гэж үзн. Өөрөөр хэлбэл, тендерийн хүчинтэй байдал, түүний агуулгад нөлөөлөхгүй хэлбэрийн төдий алдаа, зөрүү нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

#### Ерөнхий нөхцөлийг магадлахад анхаарах зарим асуудал

2.10. Тендерт оролцогчийг ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзэх үндэслэлийг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан ба тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн дагуу гаргасан мэдэгдэлд тус нөхцөл зөрчигдөөгүй тухай дурдсан бол захиалагч хуулийн тус хэсэгт заасан нөхцөл тус бүрийг үүсээгүй болохыг нотлохыг тендерт оролцогчоос шаардахгүй. Иймд ерөнхий нөхцөлийг магадлахдаа үүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгээр шаардсан баримт бичиг, холбогдох бусад мэдээлэлд үндэслэх ба тэдгээр баримт бичиг, мэдээллээр ерөнхий нөхцөл гэж тогтоогдоогүй бол тендерт оролцогчийн мэдэгдэлд үндэслэн ерөнхий нөхцөл хангасан гэж үзнэ.

2.11. Хэрэв тендерт ирүүлсэн баримт бичгээр тогтоогдохгүй бусад үндэслэлээр тендерт оролцогч нь ерөнхий нөхцөлийг хангаагүй байвал энэ нь түүнийг худал мэдэгдэл гаргасан гэж үзнэ.

2.12. Тендерт оролцогчтой холбоотой хэрэг маргааны тухай лавлагаа тодорхойлолтоор түүнийг хэрэг маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байсан тухай мэдээлэл ирсэн нь түүнийг шаардлага

хангаагүй гэж үзэх шууд үндэслэл болохгүй. Энэ тохиолдолд захиалагч тухайн хэрэг, маргааны үндсэн дээр тендерт оролцогчийг хангаагүй гэж үзэх үндэслэл байгаа эсэхийг тодруулан шалгах нь зүйтэй.

2.13. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтад заасан нөхцөл байдал байгаа эсэхийг магадлахдаа татварын болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийн дагуу төлөх хугацаа хэтэрсэн татвар, хураамж, төлбөр байгаа эсэх, түүнчлэн шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бөгөөд гүйцэтгээгүй төлбөр байгаа эсэхийг нягтлан шалгана.

2.14. Тендерт оролцогчийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдсан эсэхийг худалдан авах ажиллагааны цахим системээс шалгана.

#### Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд анхаарах зарим асуудал

2.15. Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг нотлох банкны мэдэгдэл нь банканд бодитой санхүүгийн үүрэг хүлээлгээгүй мэдэгдэл бол түүнийг үнэлгээнд харгалзан үзэхгүй. Жишээлбэл, тендерт оролцогчид зээл олгох асуудлыг судлан үзэх боломжтой гэх мэт мэдэгдлээр банк санхүүгийн үүрэг хүлээхгүй гэж үзнэ.

2.16. Тендерт оролцогчийг банкинд төлөх зээлийн төлбөртэй тухай лавлагаа тодорхойлолт ирсэн бол гэрээний дагуу төлвөл зохих хугацаа хэтэрсэн төлбөрийн хэмжээ нь хэд болохыг нягтлан үзэх нь зүйтэй юм.

2.17. Бараа худалдан авах тендер шалгаруулалтад нийлүүлэхээр санал болгож буй бараа нь тендерт оролцогчийн өмчлөл, эзэмшилд бэлэн байгаа эсэхээс хамаарч тендерийн баримт бичигт түргэн хөрвөх чадварын шаардлагыг ялгаатай зохицуулсан бол тухайн зохицуулалтыг баримталж хянан үзнэ.

2.18. Монгол Улсын хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн мэдээллийг хянан үзэхдээ холбогдох хууль тогтоомжийн дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тайлагнасан байвал зохих санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг харгалзан үзнэ.

2.19. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг хянан үзэхдээ аудитлагдсан тайлан нь холбогдох мэдээллийн баазаас дамжуулсан санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй тохирч байгаа эсэхийг нягтална.

#### Санал болгосон бараа, ажил, үйлчилгээ шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэхэд анхаарах зарим асуудал

2.20. Санал болгож буй бараа, ажил, үйлчилгээ шаардлага хангах эсэхийг шалгахын тулд захиалагч бараа, ажил, үйлчилгээний голлох нөхцөлийг Маягт 4-т, бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх гэрээний голлох нөхцөлийг Маягт 5-д тусгаж, тендер тус бүрийг харьцуулан шалгана.

2.21. Захиалагч тендерийн баримт бичигт тодорхойлсон “томоохон зөрүү” мөн эсэхийг тодорхойлохдоо хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг удирдлага болгох тул тухайн зөрүүг хүлээн зөвшөөрөх нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх эсэхийг нягталж үзнэ.

2.22. Захиалагч шаардлага хангаагүй гэж татгалзсан шалтгааныг нэг бүрчлэн тусгасан мэдэгдлийн төслийг Маягт 9-ын аль тохирох загварт нийцүүлэн боловсруулж, тендерт оролцогчид хүргүүлнэ.

## **БҮЛЭГ II. БАРАА, АЖИЛ, ЗӨВЛӨХӨӨС БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕНДЕРИЙГ ҮНЭЛЭХ**

### **3. Тендерийн үнийг тодорхойлох**

3.1. Захиалагч тендерийн үнэд арифметик алдаа байгаа эсэхийг шалгах шаардлагатай ба хэрэв байвал тендерийн баримт бичигт зааснаар залруулна. Ийнхүү арифметик алдааг залруулах болон санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцоход Маягт 6-г баримтална. Арифметик алдааг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсоны үр дүнд аль нэг тендерийн үнэ өөрчлөгдөж өөр тендерийн үнээс өссөн буюу буурсан бол энэ тухай тайлбарыг тус маягтад хавсаргана.

3.2. Үнийн хөнгөлөлтийг хувиар илэрхийлсэн бол үнийн хөнгөлөлтийг зохих суурь дүнгээс, суурь дүнгийн арифметик алдааг залруулсан бол залруулсан дүнгээс тооцож (жишээлбэл, үнийн хөнгөлөлт нь магадлашгүй зардалд хамаарах эсэхийг шалгах) Маягт 6-ийн (4) дүгээр баганад тооцоолон тусгана.

3.3. Хэд хэдэн багцад гэрээ байгуулах нөхцөлтэй санал болгосон үнийн хөнгөлөлтийг (эсхүл үнийг өсгөх өөрчлөлтийн) үнэлгээний бусад бүх шатыг дууссаны дараа харгалзан үзнэ.

3.4. Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтад ирүүлсэн тендер нь захиалагчийн урьдчилан таамаглаагүй ажил буюу нэр заасан туслан гүйцэтгэгчид хуваарилсан гэх мэт магадлашгүй ажлын зардлыг агуулж болно. Энэ зардлын дүн бүх тендерийн хувьд ижил байх учраас тус дүнг тендерийг нээх үед зарлагдсан үнээс хасч тооцно. Гэвч эдгээр магадлашгүй зардал нь тендерт оролцогчоос санал болгох өрсөлдөөнт үнэ бүхий ажил-өдөрт хамаарах тохиолдолд энэ дүнг хасахгүй.

3.5. Тендерийн баримт бичигт заасан бол үйл ажиллагааны гүйцэтгэлийн болон үйлчилгээний хүчин зүйлүүдийг үнэлгээнд харгалзана. Эдгээр хүчин зүйлийг ашиглах аргачлал нь тендерийн баримт бичгийн дагуу байх бөгөөд аргачлалын дагуу үнэлгээг хэрхэн хийснийг үнэлгээний тайланд дэлгэрэнгүй тайлбарлана.

3.6. Тендерийн баримт бичигт мөнгөөр тооцож болох зөрүүг онцгойлон заагаагүй бол тендерийн баримт бичигт заасан шаардлагыг давуулж биелүүлсэн тендерийн үнэ, харьцуулах үнийг бууруулахгүй, мөн урамшуулал олгохгүй.

3.7. Энэ зааврын 3.5-т зааснаар үнэлэхэд нэг тендерт бүтээгдэхүүний өөр өөр загварыг санал болгосон тохиолдолд тендерийн баримт бичигт нийцэж буй загваруудынх нь хамгийн бага үнийг үндэслэж сонгоно.

### **4. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох, тендерт оролцогчид олгох давуу эрхийг тооцоолох**

4.1. Захиалагч тендерийн баримт бичигт зааснаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлно.

4.2. Мөнгөөр үнэлж болох зөрүүтэй тендерийг шаардлагад нийцсэн гэж үзсэн бол дараах аргачлалаар уг зөрүүг үнэлж тендерийн үнэлгээнд харьцуулах зорилгоор харгалзана. Үүнд:

4.2.1. Тендерт оролцогчоос тодорхойгүй шаардлага, нөхцөл (тухайлбал, “урьдчилгаа төлбөрийн хэмжээг ихэсгэхийг хүсч байна” эсвэл “дуусгах хуваарийг өөрчлөх талаар хэлэлцэхийг хүсч байна” гэх мэт)-ийг тендерийн баримт бичгээс зөрүүтэй санал болгосныг тендерийн баримт бичигт заасан шаардлагаас тэс өөр хөдлөшгүй санал биш гэж үзсэний үндсэн дээр шаардлага хангасанд тооцсон бол үүний дагуу харьцуулах үнэд өөрчлөлт оруулахгүй;

4.2.2. Хэрэв бараа, үйлчилгээг гүйцэтгэх хуваарь нь тендерийн баримт бичигт заасан хугацаанаас хэтэрсэн ба үүнийг захиалагч хүлээн зөвшөөрөх боломжтой гэж үзсэний үндсэн дээр шаардлага хангасанд тооцсон бол хэтэрсэн хугацааг тендерийн баримт бичигт заасан хэмжээгээр үнэлж, заагаагүй бол гэрээний нөхцөлөөр тооцох алдангийн хувь хэмжээгээр тооцож тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

4.3. Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх тендерийн баримт бичигт зааснаар тендерт оролцогчдод давуу эрх олгоход энэ аргачлалын 5, 6 дугаар зүйлийг тус тус баримтлан давуу эрхийг тооцно.

4.4. Захиалагч тендер оролцогчид давуу эрх олгож гэрээ байгуулсан бол энэ тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу жилийн эцсийн тайланд тусгах ба гэрээний хэрэгжилтийн явцад давуу эрх тооцсон үндэслэл биелэгдсэн эсэхийг заавал нягтална.

4.5. Энэ зааврын 5.2.3, 6.2.2-т заасан орон нутаг гэдэгт холбогдох хууль тогтоомжийн дагуу хот гэж тооцогдоогүй бусад засаг захиргааны нэгжийг ойлгоно.

## **5. Бараа нийлүүлэх тендер ирүүлсэн оролцогчид давуу эрх олгох**

5.1. Бараа нийлүүлэхээр ирүүлсэн шаардлагад нийцсэн тендерүүдийг “А”, “Б”, “В” гэсэн ангилалд хуваана.

5.2. Доор дурдсан этгээд холбогдох нотлох баримтаа зохих ёсоор ирүүлснийг захиалагч хянан үзэж баталгаажуулсан бол А ангилалд хамааруулна.

5.2.1. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.20 заасан Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэх ирүүлсэн тендерт оролцогч;

5.2.2. Хог хаягдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.20 заалт зааснаар хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх санал ирүүлсэн тендерт оролцогч;

5.2.3. Шаардлага хангасан тендерүүд дотроос санал болгосон барааг нь үйлдвэрлэхэд хамгийн их үнийн дүн бүхий орон нутагт үйлдвэрлэсэн



бараа, материал, үзүүлж байгаа үйлчилгээг ашиглахаар санал болгосон нэг тендерт оролцогч;

5.2.4. Инновацийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад заасан инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Монгол Улсын дотоодын аж ахуйн нэгж.

5.3. Энэ зааврын 5.2.1, 5.2.2-т заасан “А” ангиллын тендерт оролцогч нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бол түүнийг “Б” ангилалд хамруулна.

5.4. Захиалагч хянан үзээд шаардлага хангасан гэж үзсэнтендерүүдээс “А” эсвэл “Б” ангилалд хамаарахгүй бусад тендерт оролцогчийг “В” ангилал гэж үзнэ.

5.5. Тендерт оролцогчийн бараа нийлүүлэх тендерийн үнээс хийсвэрээр бууруулах дүнг тооцоолох суурь үнэ нь зөвхөн тухайн тендерт санал болгосон Монгол Улсын гарал үүсэлтэй барааны нийлбэр үнэ байна.

5.6. Энэ зааврын 5.5-д заасан Монгол Улсын гарал үүсэлтэй барааг тодорхойлохдоо хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.20-д заасан бараа болохыг эрх бүхий байгууллагаас нотолсон байхаас гадна түүний тендерт тодорхойлсон үнэ нь үнэн бодитой байх шаардлагатай юм.

5.7. “А” ангиллын тендерт оролцогчийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны нийлбэр үнийг 10 хувиар, “Б” ангиллын тендерт оролцогчийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны нийлбэр үнийг 15 хувиар тус тус бууруулж, түүний тендерийн харьцуулах үнийг тодорхойлохдоо энэ зааврын Маягт 8-ын 1 дүгээр хүснэгтийг ашиглана.

5.8. Ажил гүйцэтгэх тендер ирүүлсэн тендерт оролцогч нь энэ зүйлд заасан “А” эсхүл “Б” ангиллын тендерт оролцогч бол түүний ирүүлсэн ажил гүйцэтгэх тендерийн хүрээнд нийлүүлэх Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг энэ зааврын 5.6-д зааснаар хийсвэрээр бууруулна.

## **6. Ажил гүйцэтгэх тендер ирүүлсэн оролцогчид давуу эрх олгох**

6.1. Ажил гүйцэтгэхээр ирүүлсэн шаардлагад нийцсэн тендерүүдийг “А”, “Б” гэсэн ангилалд хуваана.

6.2. Доор дурдсан этгээд холбогдох нотлох баримтаа зохих ёсоор ирүүлснийг захиалагч хянан хянан үзэж баталгаажуулсан бол “А” ангилалд хамааруулна:

6.2.1. Ажлын 50-иас доошгүй хувийг нь бие даан гүйцэтгэхээр тендер ирүүлсэн Монгол Улсын иргэн, өмчийнх нь 50-иас доошгүй хувийг Монгол

Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшдэг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд;

6.2.2. Шаардлага хангасан тендерүүд дотроос хамгийн их ажиллах хүчийг орон нутгаас авсан нэг тендерт оролцогч;

6.2.3. Нийгмийн даатгалд бүртгэлтэй ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж.

6.3. Ажил гүйцэтгэхээр ирүүлсэн шаардлагад нийцсэн тендерүүдийн “А” ангилалд хамаарахгүй бусад тендерт оролцогчийг “Б” ангилал гэж үзнэ.

6.4. Тендерт оролцогчийн ажил гүйцэтгэх тендерийн үнээс хийсвэрээр бууруулах дүнг тооцоолох суурь үнэ нь зөвхөн тухайн тендерт тусгасан ажилтны цалин хөлсний зардлын нийлбэр үнэ байна.

6.5. “А” ангиллын тендерт оролцогчийн цалин хөлсний нийлбэр үнийг 7.5 хувиар бууруулж, түүний тендерийн харьцуулах үнийг тодорхойлохдоо энэ зааврын Маягт 8-ын 2 дугаар хүснэгтийг ашиглана.

## **7. Тендерийг харьцуулах**

7.1. Тендерийн баримт бичигт заасан нөхцлөөр тендерийн харьцуулах үнийг тодорхойлсны дараа шаардлага хангасан тендер тус бүрийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

7.2. Зөвлөх үйлчилгээ болон эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад холбогдох тендерийн баримт бичигт заасан аргачлалын дагуу үнэлж, гэрээ байгуулах эрх олгоно.

7.3. Тендерийн баримт бичигт хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер нь саналын хувилбартай бол захиалагч саналын хувилбарыг тендерийн баримт бичигт зааснаар хянаж үзэж, үнэлнэ.

7.4. Энэ зааврын 7.3-т зааснаар саналын хувилбарыг хянан үзэж, үнэлсэн бол энэ тухай тайланг үнэлгээний дүгнэлтэд хавсаргана.

7.5. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг тендерийн баримт бичигт заасан журмаар дахин магадлана.

7.6. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн төслийг Маягт 10-ын дагуу боловсруулж, хүргүүлнэ. Ийнхүү мэдэгдэл хүргүүлэх хугацаа нь тендерт оролцогч захиалагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах боломжтой хугацаа дууссаны дараа гэрээ байгуулах боломжтой буюу тендер хүчинтэй байх хугацаа дуусаагүй байх хугацаа байна.

7.7. Захиалагч гэрээ байгуулах эрх авснаас бусад шаардлага хангасан тендер ирүүлсэн оролцогчдод хүргүүлэх мэдэгдлийг Маягт 9-ийн дагуу боловсруулж, хүргүүлнэ.

### **БҮЛЭГ III. ЗӨВЛӨХ ҮЙЧИЛГЭЭНИЙ САНАЛ ҮНЭЛЭХ**

#### **8. Зөвлөх үйлчилгээний хураангуй жагсаалтад орох саналыг хянах**

8.1. Захиалагч зөвлөх үйлчилгээний зарлалд заасан шаардлагын дагуу ирүүлсэн баримт бичгийн хүрээнд тендерт оролцогчийг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан ерөнхий нөхцөлийг хангаж байгаа эсэхийг магадалж, захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзнэ.

8.2. Энэ зааврын 8.1-т зааснаар хянан үзэхэд шаардлага хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг сонгож, хураангуй жагсаалт гаргана.

8.3. Захиалагч хураангуй жагсаалтад орсон зөвлөхөд Маягт 11-ийн дагуу боловсруулсан саналын урилгыг хүргүүлж, саналын урилга хүргүүлсэн зөвлөхийн мэдээллийг цахим системд нийтэлнэ.

8.4. Хураангуй жагсаалтад ороогүй зөвлөхөд шалтгааныг тодорхой заасан мэдэгдлийг Маягт 12-ын дагуу боловсруулж, хүргүүлнэ.

#### **9. Зөвлөх үйлчилгээний техникийн санал үнэлэх**

9.1. Хураангуй жагсаалтад орсон зөвлөхийн ирүүлсэн техникийн саналыг дараахаас бусад тохиолдолд заавал оноо өгч үнэлнэ:

9.1.1. хураангуй жагсаалтад орсны дараагаар хуулийн 14 дүгээр зүйлд заасан ерөнхий нөхцөлийг хангахгүй байх нөхцөл байдал бий болсон, эсхүл энэ тухай урьд нь мэдэгдэх боломжгүй нөхцөл байдал илэрхий болсон;

9.1.2. техникийн болон санхүүгийн саналыг илгээхдээ тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүйгээс тендерийг хүчинтэй гэж үзэх боломжгүй болсон;

9.1.3. тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтын хувьд баталгаа ирүүлээгүй, эсхүл зохих шаардлага хангаагүй баталгаа ирүүлсэн.

9.2. Энэ аргачлалын 9.1-т зааснаас бусад тохиолдолд хураангуй жагсаалтанд орсон тендерт оролцогчийн саналыг үнэлэхдээ чадавхын шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр татгалзахгүй.

9.3. Захиалагч тендерийн баримт бичигт тодорхойлсон техникийн оноо тооцох аргачлал, шалгуурыг Маягт 13-т тусгаж үнэлгээнд ашиглана.

9.4. Захиалагч зөвлөх үйлчилгээний тендерт техникийн оноо өгөхдөө энэ зааврын 9.1-т заасан үндэслэлээр татгалзахаас бусад тендерт оролцогчийн тендерийг Маягт 14-ыг ашиглаж техникийн оноо өгч эрэмбэлэнэ. Ингэхдээ техникийн санал тус бүрийн давуу болон сул талуудыг тодорхойлж, бичнэ.

9.5. Үнэлгээний хорооны гишүүд нь техникийн оноонд санал өгөхдөө сул болон давуу талууд дээр үндэслэн оноо өгөх зарчмыг баримтлах нь зүйтэй ба үндэслэлгүйгээр оноог хэт хасах, эсхүл нэмэгдүүлэхгүй. Гишүүдийн өгсөн оноог нэгтгэсний дараа оноо нэмэх, хасах, эсхүл энэ тухай санал гаргахгүй.

9.6. Энэ зааврын 9.5-д зааснаар чанарын үнэлгээний болон бага үнийн аргаар зохион байгуулж байгаа тендер шалгаруулалтад оноо өгөхдөө зөвлөх тус бүрт Маягт 15-ын дагуу оноо өгч, дундаж оноог гаргана.

9.7. Үнэлгээний дүгнэлтэд оноо өгсөн үндэслэлийг тайлбарлаж, техникийн доод оноо авсан зөвлөх тус бүртэй цаашид хэлэлцээ хийх тохиолдолд анхаарах асуудлыг тусгасан байна.

9.8. Зөвлөх сонгох хосолмол үнэлгээний аргаар зохион байгуулсан тендер шалгаруулалтад техникийн оноо өгч үнэлсэн талаар захиалагчийн мэдэгдэлд авсан онооныг нь тоог тодорхой заах ба мэдэгдлийг Маягт 16-ын дагуу боловсруулж, хүргүүлнэ.

9.9. Хэрэв зөвлөх сонгох хосолмол үнэлгээний аргаар зохион байгуулж байгаа тендер шалгаруулалтад санхүүгийн санал нээх нөхцөл үүссэн бол захиалагч санхүүгийн санал нээх хугацааг энэ зааврын 9.8-д заасан мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа байхаар заана.

## **10. Зөвлөх үйлчилгээний санхүүгийн санал үнэлэх**

10.1. Зөвхөн зөвлөх сонгох хосолмол үнэлгээний арга, бага үнийн аргаар зохион байгуулж байгаа тендер шалгаруулалтын санхүүгийн саналыг нээхдээ Маягт 17-ийн дагуу санхүүгийн саналын нээлтийн тэмдэглэл хөтөлнө.

10.2. Санхүүгийн саналын арифметик алдааг залруулах, үнийн хөнгөлөлтийг тооцох, тохируулга хийх тохиолдолд Маягт 6, Маягт 7-г тус тус ашиглана.

10.3. Зөвлөх сонгох хосолмол үнэлгээний аргаар зохион байгуулж буй тендер шалгаруулалтын хэлэлцээ хийх эрх олгох этгээдийг тодорхойлохдоо Маягт 18-ыг баримтална.

10.4. Зөвлөх сонгох чанарын үнэлгээний арга, бага үнийн аргаар зохион байгуулж байгаа тендер шалгаруулалтын хэлэлцээ хийх этгээдийг тодорхойлохдоо хуулийн 38 дугаар зүйлийн 38.3, 39 дүгээр зүйлийн 39.14 дэх хэсгийг тус тус баримтална.

-оОо-

**Маягт 1 Тендер шалгаруулалтын товч мэдээлэл**

ТӨСӨЛ

## Маягт 2 Тендерийн нээлтийн тэмдэглэлийн загвар

Тендер шалгаруулалтын нэр, дугаар: \_\_\_\_\_

Тендер хүлээн авах эцсийн хугацаа (сунгасан бол сүүлийн сунгасан хугацаа): [●] оны [●] дугаар сарын [●] өдрийн [●] цаг [●] минутын байдлаар ирүүлсэн доорхи тендерүүдийг мөн өдрийн [●] цаг [●] минутанд нээж, дор дурдсан мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэв.

№	Тендерт оролцогчийн		Тендерийн		Бусад мэдээлэл		
	Нэр (1)	Регистрийн дугаар (2)	Үнэ (3)	Үнийн хөнгөлөлт (4)	Хувилбарт тендер бол саналын хувилбарын үнэ (5)	Тендерийн баталгаа(6)	Тендерийг өөрчилсөн, эсхүл татгалзсан (7)
1							
2							
3							
4							
5							

### Маягт 3 Тендерт оролцогчийн тендерийг хянан үзэх тэмдэглэлийн маягт

Хүснэгт 1. Тендерийн хэлбэрийн шаардлагыг урьдчилан хянан үзсэн тэмдэглэл

	Шалгуур		Тендер т оролцо гч 1	Тендер т оролцо гч 2	Тендер т оролцо гч 3	Тендер т оролцо гч 4	Тендер т оролцо гч 5
1	<b>Тендерийг баталгаажуулах, илгээх шаардлагыг хангасан эсэх</b>	Эрх бүхий этгээд баталгаажуулсан					
		Итгэмжлэл					
		Ил болгох шаардлагыг хангасан					
2	Тендерийн баримт бичгийн маягтууд нь шаардлага хангасан эсэх						
3	Тендерт оролцогч шаардлага хангах эсэх		(Доорх хүснэгтэд үндэслэнэ)	(Доорх хүснэгтэд үндэслэнэ)	(Доорх хүснэгтэд үндэслэнэ)	(Доорх хүснэгтэд үндэслэнэ)	(Доорх хүснэгтэд үндэслэнэ)
4	Барааны гарал үүсэл тохирох эсэх (зөвхөн барааны хувьд хэрэглэнэ)						
5	Тендерийн баталгаа	Үнийн дүн (үнийн дүнг бич)	(үнийн дүнг бич)	(үнийн дүнг бич)	(үнийн дүнг бич)	(үнийн дүнг бич)	(үнийн дүнг бич)
		Хугацаа (хүчинтэй байх хугацааг бич)	(хүчинтэй байх хугацааг бич)	(хүчинтэй байх хугацааг бич)	(хүчинтэй байх хугацааг бич)	(хүчинтэй байх хугацааг бич)	(хүчинтэй байх хугацааг бич)
Шаардлага хангасан эсэх							
Тэмдэглэл							

Хүснэгт 2. Тендерт оролцогчийг шаардлага хангах эсэхийг хянан үзсэн тэмдэглэл

	Шалгуур	Тендерт оролцог ч 1	Тендерт оролцог ч 2	Тендерт оролцог ч 3	Тендерт оролцог ч 4	Тендерт оролцог ч 5

1	Ерөнхий нөхцөлийг хангах эсэх						
2	Гадаадын этгээд оролцохгүй тендер шалгаруулалт эсхүл багцад гадаадын этгээд тендер ирүүлсэн эсэх						
	Дангаар эсхүл түншлэлээр оролцож байгаа эсэх						
3	Түншлэл бол гэрээ шаардлага хангах эсэх						
5	Түншлэлийн гишүүд нь захиалагчаас хараат биш						
6	Зөвхөн нэг тендер ирүүлэх шаардлагыг хангасан эсэх						
7	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтанд байхгүй						
	Чадавхийн шаардлага	Санхүүгийн					
	хангасан эсэх	Техникийн чадавхи, туршлага					
	Шаардлага хангасан эсэх						
	Тэмдэглэл						



**Маягт 4 Санал болгосон бараа, ажил, үйлчилгээ шаардлага хангах эсэхийг хянан үзсэн тэмдэглэл**

Тендер шалгаруулалтын нэр:

Багцын дугаар:

	Шаардлага (Бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой захиалагчийн тавьсан шаардлагыг жагсаан бичнэ)	Тендерт оролцогч 1	Тендерт оролцогч 2	Тендерт оролцогч 3	Тендерт оролцогч 4	Тендерт оролцогч 5
1						
2						
3						
5						
6						
7						
	<b>Шаардлага хангасан эсэх</b>					
	<b>Шаардлага хангаагүй бол энэ тухай тайлбар</b>					

**Маягт 5      Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх голлох нөхцөл нь шаардлага хангах эсэхийг хянан үзсэн тэмдэглэл**

Тендер шалгаруулалтын нэр:

Багцын дугаар:

	Шаардлага (Тендерийн баримт бичигт тусгагдсан голлох нөхцөлийг жагсаан бичнэ)	Тендерт оролцогч 1	Тендерт оролцогч 2	Тендерт оролцогч 3	Тендерт оролцогч 4	Тендерт оролцогч 5
1	Нийлүүлэх хугацаа					
2	Төлбөрийн нөхцөл					
3	Тендерийн баримт бичгийн бусад нөхцөлийг хүлээн зөвшөөрөхгүй тухай илэрхийлсэн эсэх					
	Шаардлага хангасан эсэх					
	Шаардлага хангаагүй бол энэ тухай тайлбар					

## Маягт 6 Тендерийн үнэ тодорхойлох хүснэгт

Тендер шалгаруулалтын нэр:

Багцын дугаар:

	Тендерт оролцогч <sup>1</sup>	Тендерийн зарлагдсан үнэ <sup>2</sup>	Арифметик алдааны залруулах үнэ <sup>3</sup>	Үнийн хөнгөлөлтийн дүн <sup>4</sup>	Залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон тендерийн үнэ
	(1)	(2)	(3)	(4)	(5)=(2)+(3)-(4)
1	Тендерт оролцогч 1				
2	Тендерт оролцогч 2				
3	Тендерт оролцогч 3				

Тендерийн валютаас өөр үнийн дүнгээр илэрхийлэгдсэн дүнг тендер зарлах өдрийн ..... ханшаар тооцож тусгана.

<sup>1</sup> Зөвхөн шаардлага хангасан тендер ирүүлсэн тендерт оролцогчийн тендерийг (... маягтын ... дүгээр багана) энэ болон дараагийн хүснэгтүүдэд хамруулна.

<sup>2</sup> 2 дугаар маягтын (3) дугаар баганаас авна.

<sup>3</sup> Энэ багана дахь залруулах дүнг холбогдох аргачлалаар тооцох ба эерэг эсхүл сөрөг байж болно.

<sup>4</sup> 2 дугаар маягтын (4) дүгээр баганад заасан үнийн хөнгөлөлтийг тендерт оролцогчийн санал болгосон аргачлалаар тооцож бичнэ. Аргачлалын дагуу тендерийн үнэ өсөхөөр бол үнийн хөнгөлөлтийг "-" тэмдэгтэй бичнэ.

**Маягт 7      Нэмэлт тохируулга хийх хүснэгт**

Тендер шалгаруулалтын нэр:

Багцын дугаар:

	Тендерт оролцогч	Залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон тендерийн үнэ <sup>5</sup>	Нэмэлт <sup>6</sup>	Тохируулга <sup>7</sup>	Мөнгөөр үнэлж болох зөрүү	Нийт үнэ
	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)= (2)+(3)-(4)+(5)
1	Тендерт оролцогч 1					
2	Тендерт оролцогч 2					
3	Тендерт оролцогч 3					

<sup>5</sup> 6 дугаар маягтын (5) дугаар баганаас авна.

<sup>6</sup> .....

<sup>7</sup> .....

## Маягт 8 Тендерт оролцогчид олгох давуу эрх тооцоолох маягт

### Хүснэгт 1. БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ОЛГОХ ДАВУУ ЭРХ ТООЦООЛОХ МАЯГТ

Үнэлгээний валют: .....

№	Тендер т оролцог ч	Давуу эрхийн ангила л <sup>8</sup>	Давуу эрх олгохын өмнөх харьцуул ах нийт үнэ <sup>9</sup>	Давуу эрхэд хамрагд ах дүн <sup>10</sup>	Давуу эрхээр хийсвэрл эн бууруула х хувь <sup>11</sup> %	Давуу эрхээр хийсвэрл эн бууруула х дүн	Харьцуул ах нийт үнэ
	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)=(4)*(5)	(7)=(3)-(6)
1							
2							
3							
4							

<sup>8</sup> 2 дугаар баганад тендерт оролцогчийн холбогдох баримтаа ирүүлж, захиалагчийн нягтлан үзэж тогтоосон “А”, “Б”, эсхүл “В” ангиллыг бичнэ.

<sup>9</sup> Хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, 28.7.1 дэх заалтын дагуу тооцоолсон харьцуулах үнэ байна

<sup>10</sup> Монгол Улсын гарал үүсэлтэй барааны нийлбэр дүн байна

<sup>11</sup> “А” ангиллын тендерт оролцогчийн хувьд 10%, “Б” ангиллын тендерт оролцогчийн хувьд 15%, “В” ангиллын хувьд 0% байна.

**Хүснэгт 2. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ОЛГОХ ДАВУУ ЭРХ  
ТООЦООЛОХ МАЯГТ**

Үнэлгээний валют: .....

№	Тендерт оролцогч	Давуу эрхийн ангилал <sup>12</sup>	Давуу эрх олгохын өмнөх харьцуулах нийт үнэ <sup>13</sup>	Давуу эрхэд хамрагдахгүй дүн <sup>14</sup>	Давуу эрхэд хамрагдах дүн	Давуу эрхээр хийсвэрлэн бууруулах хувь <sup>15</sup> %	Давуу эрхээр хийсвэрлэн бууруулах дүн	Харьцуулах нийт үнэ
	(1)	(2)	(3)	(4)	(5)=(3)-(4)	(6)	(7)=(5)*(6)	(8)=(3)-(7)
1								
2								
3								
4								

<sup>12</sup> 2 дугаар баганад тендерт оролцогчийн холбогдох баримтаа ирүүлж, захиалагчийн нягтлан үзэж тогтоосон “А” эсхүл “Б” ангиллыг бичнэ.

<sup>13</sup> Хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, 28.7.1 дэх заалтын дагуу тооцоолсон харьцуулах үнэ байна

<sup>14</sup> Ажил гүйцэтгэх тендерийн хүрээнд нийлүүлэх барааны нийлбэр дүн байна

<sup>15</sup> “А” ангиллын тендерт оролцогчийн хувьд 7.5%, “Б” ангиллын тендерт оролцогчийн хувьд 0% байна.

## Маягт 9 Тендер шалгараагүй тухай мэдэгдлийн загвар

Загвар 1. Тендерт оролцогчийн тендерээс татгалзах мэдэгдлийн загвар

[Шаардлагагагүй хангаагүй гэж татгалзах болон хамгийн бага санал ирүүлсэн тендер биш гэж татгалзах маягт нь ялгаатай байх]

(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

**[ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН НЭР]**

[огноо]

### Мэдэгдэл хүргүүлэх тухай

**[Тендер шалгаруулалтын нэр, дугаар]**-ын тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт заасны дагуу дараах шаардлагыг хангаагүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

№	Захиалагчийн тавьсан шаардлага	Тендерт оролцогчийн санал	Шалгараагүй тухай тайлбар
1			
2			
...			

Уг тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул хуулийн 30 дугаар зүйлийн **[тохирох заалтыг бичиг]** дэх заалтын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах болсныг мэдэгдье.

Дээрх тендер шалгаруулалтад ..... ХХК-нд гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэл хүргүүлсэн болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

**[ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН НЭР]**

[огноо]

**Мэдэгдэл хүргүүлэх тухай**

**[Тендер шалгаруулалтын нэр, дугаар]**-ын тендер шалгаруулалтад [.....] шалгарсан ба танай тендер “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгараагүй болохыгтендерт оролцогчоос өндөр үнийн санал ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4<sup>16</sup> дэх заалтын дагуу танай тендерээс татгалзсан болохыг үүгээр мэдэгдье.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

Хүндэтгэсэн,

Захиалагч байгууллагын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

---

<sup>16</sup> Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хуулийн 28.7.5 дахь заалтыг ишлэх.



(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

**[ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН НЭР]**

[огноо]

### Гэрээ байгуулах эрх олгох тухай

**[Тендер шалгаруулалтын нэр, дугаар]**-ын тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4<sup>17</sup> дэх хэсэгт заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгож буйг үүгээр мэдэгдэж байна.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6 хоногийн дараа **[огноо]-ны өдрийн** дотор **[мөнгөн дүн<sup>18</sup>]** төгрөгийн гүйцэтгэлийн баталгааны<sup>19</sup> хамт гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлнэ үү.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг гарын үсэг зурсан гэрээний маягтын хамт дээрх хугацаанд багтаан ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

Захиалагч байгууллагын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

<sup>17</sup> Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хуулийн 28.7.5 дахь заалтыг ишлэх.

<sup>18</sup> Гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцож тусгах.

<sup>19</sup> Хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-т заасан бол гүйцэтгэлийн баталгаа заавал шаардана.

ЗӨВЛӨХИЙН ТЕНДЕРИЙН УРИЛГА<sup>20</sup>

Огноо : \_\_\_\_\_

1. **[Захиалагч байгууллагын нэр]** нь **[төслийн/үйлчилгээний нэр, дугаар]**-ийг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул **[үйлчилгээний зорилго болон товч танилцуулга]** гүйцэтгэх тухай санал ирүүлэхийг урьж байна.

2. Зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг хураангуй жагсаалтад орсон дараах зөвлөхүүдэд хүргүүлж байна: **[Зөвлөхийн хураангуй жагсаалт]**

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн энэхүү зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон **[үнэлгээний арга<sup>21</sup>]** аргад үндэслэн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгоно.

4. Зөвлөхийн саналын урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй байна. Үүнд:

**Бүлэг 1 - Урилга**

**Бүлэг 2 - Зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгаа (Тендерийн өгөгдлийн хүснэгтийн хамт)**

**Бүлэг 3 - Техникийн санал - жишиг маягт**

**Бүлэг 4 - Санхүүгийн санал - жишиг маягт**

**Бүлэг 5 - Ажлын даалгавар**

**Бүлэг 6 - Гэрээний жишиг маягт**

**Бүлэг 7- Тендерийн баталгаа /Хэрэв шаардсан бол/**

5. Энэхүү баримт бичгийг хүлээн авсан тухай албан ёсоор мэдэгдэнэ үү.

**[Захиалагчийн тодорхой хаяг**

**(өрөөний дугаар, харилцах албан тушаалтны нэр, утас/факс)]**

<sup>20</sup> Энэхүү урилгыг хураангуй жагсаалтад орсон этгээдэд Үнэлгээний хорооны даргын албан бичгээр хүргүүлнэ.

<sup>21</sup> Хосолмол үнэлгээний арга, бага үнийн арга, чанарын үнэлгээний аргын аль нэгийг сонгоно уу.

**Маягт 12 Зөвлөх үйлчилгээний хураангуй жагсаалтад ороогүй тухай  
мэдэгдлийн загвар**

Зөвлөх үйлчилгээний хураангуй жагсаалтад ороогүй тухай мэдэгдэл

ТӨСӨД

**Маягт 13 Зөвлөх үйлчилгээний техникийн санал үнэлэх шалгуур үзүүлэлтийн загвар**

Үнэлгээний шалгуур үзүүлэлт/дэд үзүүлэлт:

(а) зөвлөхийн туршлага

- (1) \_\_\_\_\_
- (2) \_\_\_\_\_

Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_

(б) аргачлал

- (1) \_\_\_\_\_
- (2) \_\_\_\_\_

Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_

(в) голлох ажилтнууд

- (1) хувь хүн
  - (А) \_\_\_\_\_
  - (Б) \_\_\_\_\_
  - (В) \_\_\_\_\_
- (2) хэсэг
  - (А) \_\_\_\_\_
  - (Б) \_\_\_\_\_
  - (В) \_\_\_\_\_

Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_

(г) сургалт (шаардлагатай бол)

- (1) \_\_\_\_\_
- (2) \_\_\_\_\_

Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_

(д) дотоодын оролцоо (олон улсын тендер бол)

- (1) \_\_\_\_\_
- (2) \_\_\_\_\_

Хувийн жин \_\_\_\_\_  
Хувийн жин \_\_\_\_\_

Техникийн оноо /зөвлөх тус бүрээр

Техникийн доод оноо \_\_\_\_\_

Зөвлөхийн нэр	Техникийн оноо
1.	
2.	
3.	
4.	

**Маягт 14 Зөвлөх үйлчилгээний техникийн оноо үнэлэх хүснэгт**

**ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО – ТЕХНИКИЙН ОНОО /ЭЗЭЛСЭН БАЙР**

Зөвлөхийн нэрс	<i>[Зөвлөхийн нэрийг бич]</i>	<i>[Зөвлөхийн нэрийг бич]</i>	<i>[Зөвлөхийн нэрийг бич]</i>	<i>[Зөвлөхийн нэрийг бич]</i>
Шалгуур үзүүлэлт	Оноо	Оноо	Оноо	Оноо
Туршлага				
Аргачлал				
Санал болгож буй ажилтнууд				
Сургалт				
Дотоодын оролцоо				
<b>Бүгд оноо<sup>а</sup></b>				
Эзэлсэн байр				

а. Техникийн доод онооноос доогуур оноо авсан техникийн саналыг хассан болно.

**Маягт 15 Зөвлөх үйлчилгээний тендерт оноо өгөх хүснэгтийн загвар**

Үнэлгээний хорооны гишүүдийн Үнэлгээ<sup>22</sup>

Зөвлөхийн нэр: \_\_\_\_\_

Үзүүлэлт/дэд үзүүлэлт	Авч болох дээд оноо	Үнэлгээний хорооны гишүүд					Дундаж оноо
		1	2	3	4	5	
Туршлага							
-							
-							
-							
Аргачлал							
-							
-							
-							
Голлох ажилтнууд							
-							
-							
-							
Сургалт <sup>а</sup>							
-							
-							
-							
Дотоодын оролцоо <sup>а</sup>							
-							
-							
<b>Бүгд</b>	<b>100</b>						

а. Зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичигт шаардсан бол

1. Гишүүн: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

2. Гишүүн: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

3. Гишүүн: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

<sup>22</sup> Энэ маягыг чанарын үнэлгээний болон бага үнийн арга хэрэглэх үед ашиглана..

4. Гишүүн: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо:  
\_\_\_\_\_

5. Гишүүн: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо:  
\_\_\_\_\_

ТӨСӨЛ

Маягт 16 Зөвлөх үйлчилгээний техникийн саналын оноо өгсөн тухай  
мэдэгдлийн төсөл

ТӨСӨЛ



**Маягт 17 Зөвлөх үйлчилгээний санхүүгийн саналын нээлтийн тэмдэглэл**

Тендер шалгаруулалтын нэр, дугаар: \_\_\_\_\_

Санхүүгийн саналын нээлтийг оролцогчод мэдэгдсэн [●] оны [●] дугаар сарын [●] өдрийн [●] цаг [●] минутанд нээж, дор дурдсан мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэв.

№	Тендерт оролцогчийн		Техникийн оноо (3)	Санад болгосон үнэ		Бусад мэдээлэл (6)
	Нэр (1)	Регистрийн дугаар (2)		Үнэ (4)	Үнийн хөнгөлөлт (5)	
1						
2						
3						
4						
5						

Зөвлөхийн төлөөлөгч

№	Нэр	Гарын үсэг
1		
2		
3		
4		
5		

**Маягт 18 Хосолмол үнэлгээний аргаар гэрээ байгуулах эрх олгох хүснэгт**

Зөвлөхийн нэрс	Техникийн саналын үнэлгээ			Санхүүгийн саналын үнэлгээ		Хосолмол үнэлгээ	
	Техникийн оноо <sup>23</sup> S(t)	Хувийн жинд үржүүлсэн оноо S(t) × T <sup>24</sup>	Техникийн хувьд эзэлсэн байр	Санхүүгийн оноо <sup>B</sup> S(f)	Хувийн жинд үржүүлсэн оноо S(f) × F <sup>25</sup>	Нийт оноо S(t)*T + S(f)*F	Эзэлсэн байр
Хамгийн сайн үнэлэгдсэн тендер	Хосолмол үнэлгээгээр хамгийн дээд оноо авсан зөвлөхөд: Зөвлөхийн нэр: _____						

<sup>23</sup> Маягт 14-ын бүгд оноог үзнэ үү.

<sup>24</sup> Тендерийн баримт бичиг заасан хувийн жинг үзнэ үү.

<sup>25</sup> Тендерийн баримт бичиг заасан хувийн жинг үзнэ үү.